



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Энхтайваны өргөн чөлөө 23, Юу Би Эйч төв, 8 давхар,
Утас: 26 01 82

2024.05.27 № 04/850
танай _____-ны № _____-т

ЭМЯ-НЫ МЭРГЭЖЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛҮҮД,
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ,
ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВ,
АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН НЭГДСЭН
ЭМНЭЛЭГ,
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Шинжээч сонгон шалгаруулах тухай

Тус агентлаг нь Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын А/233 дугаар тушаалаар батлагдсан "Бүртгэлийн шинжээч ажиллуулах журам"-ын дагуу Эм, эмийн түүхий эд, вакцин, биобэлдмэл, оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүний улсын бүртгэлийн баримт бичигт үнэлгээ хийж, дүгнэлт гаргах орон тооны бус шинжээчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна.

Иймд хавсралт дахь мэдээлэлтэй танилцан, бүртгэлийн шинжээчээр ажиллахыг хүссэн мэргэжилтний материалыг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 10.00 цаг хүртэл ажлын албанд цаасаар болон ulziidulam@mmra.gov.mn цахим хаягаар ирүүлж, хамтран ажиллана уу:

Хавсралт 2. хуудастай.

- Хувийг: 1. Монголын Эмзүйн байгууллагуудын Нэгдсэн "Эм Холбоо" ТББ;
2. Эм хангамжийн байгууллагын холбоо ТББ;
3. Эм зүйн мэргэжлээр төгсөгчдийн холбоо ТББ-д.

ЛИЦЕНЗ, ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА Л.ЗЭНДМАА



1424 150831

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 27-ны
өдрийн 1850 дугаар албан бичгийн хавсралт



БҮРТГЭЛИЙН ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага, Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөл, анагаах ухааны их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, Төрийн бус байгууллагын мэргэжилтнүүдийн дунд “Эм, эмийн түүхий эд, вакцин, биобэлдмэл, оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн баримт бичигт үнэлгээ хийж, дүгнэлт гаргах орон тооны бус шинжээч” (цаашид бүртгэлийн шинжээч гэх)-ийг сонгон шалгаруулахаар мэдээллийг хүргүүлж байна.

Бүртгэлийн шинжээч нь дараах чиглэлтэй байна. Үүнд:

- 1.1 **Эмийн бүртгэлийн Эм зүйн шинжээч:** (Эм зүйч)
Мэргэшлийн чиглэл: эмийн үйлдвэрлэл, технологи, чанарын хяналтын чиглэлээр мэргэшсэн эм зүйч-хими, эм зүйч-технологич, эмнэлзүйн эм зүйч, лабораторийн эм шинжлэгч, цацрагийн эм зүйч);
- 1.2 **Эмийн бүртгэлийн Эмнэлзүйн шинжээч:** (Хүний их эмч)
Мэргэшлийн чиглэл: Зүрх судас, Мэдрэл, Дотор, Хоол боловсруулах, Бөөр, Дотоод шүүрэл, Амьсгал, Харшил, Арьс, Хүүхэд, Хавдар, Халдварт, Ерөнхий мэдээгүйжүүлэг, Мэс засал, Сэтгэц, Наркологи, Уламжлалт анагаах ухаан, Биобэлдмэл, Вакцин, бусад.
- 1.3 **Оношлуурын бүртгэлийн шинжээч:**
Мэргэшлийн чиглэл: Биохими, Клиникийн хими, Иммунологи, Гематологи, Цус бүлэгнэлт, Серологи Патологи, Гистологи, Цитологи, Вирусологи, Молекул биологи, Микробиологи, бусад
- 1.4 **Биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн шинжээч:** Эм зүйч, Хүний их эмч, Хор судлаач, Уламжлалт анагаах ухааны эмч, Ургамал судлаач, Биологич, Генетикч.

Шинжээчид тавих шаардлага:

1. Бүртгэлийн баримт бичигт мэргэжлийн чиглэлээр үнэлгээ, дүгнэлт өгөх чадвартай, мэргэжлийн болон эрдмийн зэрэгтэй;
2. Эрүүл мэндийн салбарт холбогдох мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, дадлага туршлагатай, мэргэшсэн;
3. Эм, эмийн түүхий эд, вакцин, биобэлдмэл, оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүн ханган нийлүүлэгч, үйлдвэрлэгч байгууллагад хараат бус;
4. Ёс зүйн зөрчилгүй, гэмт хэрэгт холбогдож байгаагүй.

Жич: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын А/233 дугаар тушаалаар батлагдсан "Бүртгэлийн шинжээч ажиллуулах журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтад "Хүний эмийн зөвлөлийн бүрэлдэхүүнд ажилладаг бол эмийн бүртгэлийн шинжээчээр, ХЭЗ-ийн Биобэлдмэл, оношлуурын салбар зөвлөлд ажилладаг бол оношлуурын шинжээчээр, Биологийн идэвхт бүтээгдэхүүний салбар зөвлөлд ажилладаг бол БИБ-ний шинжээчээр ажиллахыг тус тус хориглоно" гэж заасныг анхаарна уу.

Бүрдүүлэх материал:

1. Шинжээчээр ажиллахыг хүссэн өргөдөл;
2. Ёс зүйн зөрчилгүй талаарх тодорхойлолт;
3. Анкет /Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын 1-р хавсралтаар/;
4. Иргэний үнэмлэхний хуулбар эсхүл иргэний лавлагаа;
5. Боловсролын диплом, мэргэжлийн болон мэргэшүүлэх, эрдмийн зэргийн үнэмлэхний хуулбар;
6. Цээж зураг 1 хувь (3х4)
7. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээгээгүй тухай тодорхойлолт /E-Mongolia цахим сангаас авсан байх/

Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа: Бүртгэлийн шинжээчээр ажиллахыг хүссэн мэргэжилтний материалыг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 10.00 цаг хүртэл ажлын албанд цаасаар болон ulziidulam@mmra.gov.mn цахим хаягаар ирүүлнэ.

Материал хүлээн авах хаяг:

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар
158160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3 дугаар хороо,
Энхтайваны өргөн чөлөө, Энхтайван найрамдлын ордон, 207 тоот.

Сонгон шалгаруулалттай холбоотой тодруулгыг 51-260212 дугаарын утсаар Д.Өлзийдулам ахлах мэргэжилтэнтэй холбогдож авна уу